

ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ БА ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХИЙН ХАРИЛЦАН ХАМААРАЛ, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Б.Баярмаа*, Б.Наранбаатар**

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, магистр (МА)

** МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн эрхлэгч, дэд профессор, доктор (Ph.D)

Түлхүүр үгс: хэвлэлийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх, хүний эрх, хэвлэл мэдээллийн эрх зүйн зохицуулалт

Хэвлэлийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх гэсэн хоёр ойлголт ихэр мэт хэрэглэгдэх болсоор хоёр зуунтай золгожээ. Хэвлэлийн эрх чөлөөг хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтан, сэтгүүлчидтэй хамаатай гэхээс илүү хүний үндсэн эрхийн тухай асуудал, ардчиллын амин чухал үзүүлэлт гэж үзэх болсон. Сэтгүүлчид олон нийтийн эрх ашгийг хамгаалдаг учраас “тэдний” хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах нь зайлшгүй хэмээх нь хэт ерөнхий тайлбар юм. Ялангуяа дэлхий нийтээр хэвлэлийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх эрсдэлтэй нөхцөл байдалтай тулгарсан энэ цагт яагаад үзэл бодлоо илэрхийлэх эрх, хэвлэлийн эрх чөлөө хос морь шиг ижилсэж байдаг, түүний цаад зүй тогтол юу болохыг танин мэдэх нь чухал боллоо. Интернэт сүлжээ, онлайн талбар дахь олон нийтийн үзэл бодлын орон зай улам хүч нөлөөтэй болж буй, энэ нь нэг улс орноор тогтохгүй бүс нутаг, дэлхийн улс төр, нийгэм, эдийн засгийн тогт-

вортой байдалд нөлөөлж буй нь засгийн газруудыг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эсрэг хатуу арга хэмжээ авах шалтаг, шалтгаан болсон. Өнөөдөр ардчилал, хүний эрх, хүмүүнлэг нийгмийн үзэл санаа дэлхий даяар түгсэн ч хэвлэлийн эрх чөлөө эрсдэлтэй, эмзэг нөхцөлд байна. Энэхүү өгүүлэлд хэвлэлийн эрх чөлөө гэсэн ойлголтод юу багтах, үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй ямар харилцан хамааралтайг өргөн хүрээнд тайлбарлахыг зорилгоо.

1. Хэвлэлийн эрх чөлөө

Хэвлэлийн эрх чөлөө гэж хөндлөнгийн оролцоогүй, аливаа дарамт шахалтгүй байхыг хэлнэ хэмээн Олон улсын сэтгүүлчдийн холбоо Ардчилсан хэвлэлийн соёлын тунхагтаа тодорхойлжээ (Наранжаргал, 2021). “Freedomhouse” байгууллага “Олон нийтийн ашиг сонирхлын төлөө сэтгүүлчид чөлөөтэй мэдээлэх боломжтой байх нь ардчиллын чухал үзүүлэлт юм. Чөлөөт хэвлэл нь удирдагчдын алдаа, оноог мэдээлж, иргэдийн хэрэгцээ, хүсэл эрмэлзлийг төрийн байгууллагуудад хүргэж, үзэл бодлоо чөлөөтэй солилцох индэр болж байдаг. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлах үед эдгээр амин чухал үйл явц

үгүй болж, удирдагчид болон иргэдийн хэн хэнд нь хор хөнөөл учрахуйц буруу шийдвэр гарахад хүрдэг (Freedomhouse, n.d.) гэж тодорхойлсон.

Хэвлэлийн эрх чөлөө нь тодорхой зарчим, үнэлэмж бүхий идиал ойлголт юм. Хэвлэлийн эрх чөлөө нь гарт баригдаж, нүдэнд үзэгдэхгүй учраас түүнийг үнэлж, дүгнэх нь оюун санааны хүрээний асуудал болдог. Хэвлэлийн эрх чөлөө яг ямар байх ёстой талаар улс орон, байгууллага, редакц, сэтгүүлчдийн хувьд өөр өөр шалгуур, хүлээлттэй байж ирсэн. Өмнө нь хэвлэлийн эрх чөлөө гэдэг зөвхөн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад хаяглагдаж байлаа. Харин энэхүү ойлголт өдгөө хүн бүрийн амин эрхтэй холбоотой гэж тайлбарлах болсон. Үүнд хүн бүрд үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх технологийн боломж, эрх зүйн орчин бүрдсэн, олон нийтийн үзэл бодлыг ардчиллын чухал хэсэг гэж үздэг болсон нь голчлон нөлөөлж байна.

Анхандаа хэвлэлийн эрх чөлөөг үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхээр төсөөлөн ойлгож байсан. 1791 оны АНУ-ын Үндсэн хуулийн нэгдүгээр нэмэлт өөрчлөлт нь хэвлэлийн эрх чөлөөг хуулиар баталгаажуулан хамгаалах ёстой гэсэн үзэл санааг хамгийн анх дэлхий дахинд түгээсэн баримт бичиг юм. Уг баримт бичигт “Конгресс нь шашныг хуульчлан тогтоох, эсвэл үүнээс шалтгаалан чөлөөт илэрхийллийг хориглох, үг хэлэх эрх чөлөөг хязгаарлах, ард иргэдийн тайван замаар эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарласан хууль гаргаж болохгүй. Мөн Засгийн газар нь нэр төрөө сэргээлгэхээр гомдол гаргахыг хориглоно” (Whitehouse, n.d.) гэсэн байдаг. Энд үг хэлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх

чөлөөг тусад нь авч үзсэн. Үүнээс хойш АНУ-ын шүүхийн президентээр дамжуулан хэвлэлийн эрх чөлөө гэж юу болох, түүнд юу хамаарах агуулгын хүрээг тэлсээр ирсэн. Өдгөө хэвлэлийн эрх чөлөө гэсэн ойлголт нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэл авах эрх, хэвлэн нийтлэх эрх, төрийн хяналт цензурээс ангид байх, сэтгүүлчийн аюулгүй байдал, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил зэрэг нэн олон агуулгаар тодорхойлогдох болсон. Эдгээрээс аль нэг нь л учир дутагдалтай бол хэвлэлийн эрх чөлөөгүй гэж дүгнэх нь бий. Энэхүү жагсаалт цаг үе, нийгмийн өөрчлөлтийг дагаад цаашид ч өргөжин үргэлжлэх юм.

Хэвлэлийн эрх чөлөө нь улс орны хувьд нийтийн асуудал ч мөн хувь сэтгүүлч, иргэнд ч хамаатай байдаг субъектив ойлголт. Хэрэв тухайн редакц хараат бусаар ажиллаж, сэтгүүлч нь дарамт шахалтад өртдөггүй, нийгмийн зөрчилтэй сэдвийг хөндөн бичдэггүй, ямар нэг сүрдүүлэг, дарамтад өртөж байгаагүй бол хэвлэлийн эрх чөлөөг сайн гэж үнэлдэг. Харин редакц нь нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад хатуу цензур тавьдаг, улс төр болон эдийн засгийн бүлэглэлүүдийн нөлөөтэй, хэн нэгний эрх ашгийг хөндөж, илчлэн шүүмжилдэг бол хэвлэлийн эрх чөлөөг тааруу гэж үнэлдэг. Учир нь тухайн сэтгүүлчийн ажлаа хийх орчин нөхцөл нь нэг улс орны хувьд, нэг мэргэшсэн чиглэлийн хувьд, тэр байтугай нэг байгууллага доторх сэтгүүлч бүрийн нөхцөл ч ялгаатай байдгаас тэр юм. Хэвлэлийн эрх чөлөө нь үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хэрэгжүүлэх суурь нөхцөл, эдгээр эрхүүдийн хэрэгжиж буйг илтгэх үзүүлэлт билээ. Ийм нөхцөл бүрдэ-

хийн тулд зөвхөн сэтгүүл зүй, сэтгүүлчид “эрх”-үүдтэй байх нь хангалтгүй. Олон нийтийн сэтгүүл зүйд итгэх итгэл, төрийн цензур, хяналт, олон нийтийн мэдээллийн боловсрол, хууль эрх зүй болон ёс зүйн төлөвшил, эдийн засгийн нөхцөл байдал зэрэг нэн олон хүчин зүйлсийн харилцан нөлөөлөл, үр дүн нь хэвлэлийн эрх чөлөөтэй байх нөхцөлийг бүрдүүлж байдаг.

Гэхдээ хэвлэлийн эрх чөлөө нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэн нийтлэгчид туйлын эрхтэй байх тухай биш. Нэг хүний эрх нөгөө хүний эрхээр хязгаарлагдах хүний нийгмийн “гэрээ” бий. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл туйлын эрх чөлөөтэй эсвэл туйлын хариуцлагатай байх боломжгүй. Харин үүнийг тодорхой хэмжээний эрх чөлөөтэй бөгөөд тодорхой хэмжээний хариуцлагатай байх хэмээн ойлговол зохино (Эрх чөлөө болон хариуцлага нь ямар нэг хэмжигдэхүүнээр жинлэх, тооцох боломжгүй философийн ойлголт). Энэ үүднээс хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг хуулиар зохицуулах ёстой эсэхэд хариулахад илүү дөхөм юм. Хариулт нь, хэвлэлийн салбар бүрэн эрх чөлөөгүй бөгөөд тодорхой хэмжээний хууль, ёс зүйн хариуцлагатай байх нь зайлшгүй. Гэхдээ тэр хууль, дүрэм журам нь өөрөө “зайлшгүй” гэсэн нөхцөлөө бүрэн дүүрэн хангаж байх ёстой. Ингэснээр талуудад (төр, олон нийт, хэвлэл мэдээллийн салбар) харилцан ашигтай байдал бий болно. Харин туйлын бус бага зэрэг хариуцлагатай сэтгүүл зүйн салбарт хуулийн дагуу их хэмжээний хариуцлага хүлээлгэх магадлалтай учир эргээд хэвлэлийн эрх чөлөөг хумьдаг. Иймд энэхүү эрх чөлөө, хариуцлагын тэнцвэр нь чөлөөт

хэвлэлийн хууль, эрх зүйн орчны гол амин сүнс юм. Үүнийг энгийнээр тайлбарлавал эрх чөлөө, нийгмийн хариуцлага хоёрыг жинлүүр дээр тавихад аль нэг нь хэрээс хэтэрч, жин дарвал хэвлэлийн эрх чөлөөгүй орчин бий болно гэсэн үг.

Судлаачид, баримт бичгүүдийн тайлбаруудыг нэгтгэн үзвээс, хэвлэлийн эрх чөлөө гэдэг нь хэвлэн нийтлэгчид хууль эрх зүйн хүрээнд чөлөөтэй үйл ажиллагаа явуулах нөхцөлүүд, тэдгээрийн тэнцвэртэй байдал юм.

Өмнө нь хэвлэлийн эрх чөлөө бол иргэдийн үг хэлэх эрх чөлөө хэрэгжих яг таг, нарийн шалгуур гэхээс илүү ерөнхий нөхцөл гэдгийг дурдсан билээ. Тэгвэл ийм таатай орчин бий болж, хэвлэлийн эрх чөлөө үр дүнтэй байхад дараах нөхцөлүүд бүрдсэн байх ёстой гэж судлаач Дэннис Маккуэйл, Марк Дьюз нар үзсэн. Үүнд,

- Цагдан хяналтгүй, засгийн газрын зөвшөөрөл гэх мэт хянах механизмгүй байснаар мэдээлэл, үзэл бодлыг саадгүйгээр хэвлэн нийтлэх, түгээх, хэн нэгэн хэвлэн нийтлэхийг хүсээгүйгээс шалтгаалсан албадлага байхгүй;
- Эзэмшигч болон улс төр, эдийн засгийн сонирхлын бүлгүүдийн хэт хяналт, хөндлөнгийн оролцооноос жинхэнэ утгаараа хараат бус байх;
- Бүх иргэн мэдээлэл хүлээн авагчийн хувьд хэвлэн нийтэлж, дамжуулж буй сувгуудыг ашиглах боломжтой бөгөөд тэгш эрх эдлэх;
- Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн төвлөрөл, олон хэвлэл мэдээллийг нэг дор эзэмших байдлыг хязгаарласан өрсөлдөөнт зах зээл;
- Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд холбогдох эх сурвалжаас мэдээлэл олж авах эрхтэй байх (Denis

McQuail, Mark Deuze, 2021) зэрэг багтана.

Харин “Хил хязгааргүй сэтгүүлчид” (RSF) байгууллага үүнээс нарийн шалгуур гаргасан бөгөөд үүнийгээ улс төр, эдийн засаг, хууль эрх зүй, нийгэм соёл, сэтгүүлчдийн эсрэг хүчирхийлэл гэсэн таван бүлэг шалгуураар авч үзсэн. Ер нь хэвлэлийн эрх чөлөөг үнэлэх шалгуур тогтмол шинжтэй биш, тийм байх ч боломжгүйг дээр дурдсан. Тухайн цаг үеийн нийгмийн хандлага, үзэл баримтлал, шинэ үзэгдлүүдээр баяжин зарим шалгуур нэмэгдэж, зарим нь гээгдэж байдаг. Тухайлбал, сүүлийн үед интернэт сүлжээний хүртээмж, онлайнд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой байх эсэх

зэрэг шалгууруудыг нэмэх шаардлага бий болсон. “Хил хязгааргүй сэтгүүлчид”-ын шалгуур нь дэлхийн 180 гаруй орныг дээрх таван бүлэг шалгуураар үнэлэхдээ тухайн улс орны хэвлэл мэдээллийн эрх зүйн чиглэлийн мэргэжилтнүүдээс асуулгын судалгаа аван, нэмж нөхцөл байдлын үнэлгээ хийдэг байна. Энэхүү үнэлгээнд Монгол Улс “мэдэгдэхүйц асуудалтай” орны тоонд багтаж, 2023 онд 88-д эрэмбэлэгдсэн. Доорх график нь Монгол Улсын хэвлэлийн эрх чөлөөний нөхцөл байдал 2003 оноос буюу 20 жилийн өмнөхөөс төдийлөн сайжраагүй, 2015 оноос хойш энэ үзүүлэлт буурч ирснийг харуулж байна.




График 1. Монгол Улсын сүүлийн 20 жилийн хэвлэлийн эрх чөлөөний үнэлгээ. Эх сурвалж: RSF.com

2. Үзэл бодлоо илэрхийлэх эрх

Чөлөөт хэвлэл бол чөлөөт ард иргэд юм (GIC, огноо байхгүй) гэж “Чөлөөт хэвлэлийн харти” (1987)-гийн тэргүүн өгүүлбэрт бий. Хүн үзэл бодлоо илэрхийлэх нь төрөлх, жам ёсны эрх бөгөөд энэ эрхийг хөндөх нь хүн болж төрсөн эрхэм чанар (dignity)-т нь халдсан явдал юм. Хуульч Б.Чимид “Итгэл үнэмшилтэй байж, түүнээ чөлөөтэй илэрхийлэх, хамгаалах гэдэг бол хүнд өөрт нь заяагдсан

эрх болохоос хэн нэг өгөөмөр сэтгэлтний өглөг, тэр дундаа засаг төрийн олговор биш (Наранжаргал, 2021)” гэж тайлбарлажээ. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэт хязгаарлавал бусад олон эрх зөрчигдөх үндэс болдог. Хүн бүр үзэл бодлоо үгээр болон бичгээр илэрхийлэх боломжгүй бол хэвлэлийн эрх чөлөө хэрэгжихгүй. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхүүд нь эрх зүйт ёсны, үндсэн хуульт ёсны чухал элемент билээ. Эдгээр эрх нь хил хязгаар

харгалзахгүйгээр амаар, бичгээр, хэвлэмэл материал, урлагийн хэлбэрүүдээр илэрч болох бөгөөд төрөл бүрийн хэрэгслээр дамжуулж буй мэдээлэл, үзэл бодлыг хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөөг агуулдаг.

Хүн бүр эрх тэгш бөгөөд засаглалд оролцох эрхтэй гэдгийг тунхагласан хүн төрөлхтний хамгийн эртний бичмэл эх сурвалж нь Испанийн газар нутагт 910-1833 оны хооронд оршин тогтнож байсан Леоны эзэнт гүрэнтэй холбоотой. “Леоны 1188 оны зарлиг” (The Decreta or Decrees of León of 1188)-ыг 2013 онд дэлхийн соёлын өвд бүртгэсэн. Дундад зууны үеийн Испанийн төрийн байгууллагад хаан, шашны мяндагтан, язгууртны хамт тосгон, хотоос сонгогдон гарсан энгийн ард шийдвэр гаргаж ажиллах боломжийг бүрдүүлсэн төр, захиргааны анхны загварыг тус баримт бичгээр бий болгосон юм. Үүнээс улбаалан хожим боловсруулсан Британийн Магна Карта (1215), Эрх шаардах бичиг (1628), Английн Эрхийн жагсаалт (1689), Америкийн Нэгдсэн Улсын (АНУ) Үндсэн хууль (1787), Францын Хүний болон иргэний эрхийн тунхаглал (1789), АНУ-ын Эрхийн жагсаалт (1791) нь орчин цагийн хүний эрхийн тухай баримт бичгийн бичмэл эх сурвалжид тооцогддог (Болорсайхан, 2021). Эдгээр баримт бичигт уламжлагдсан хувь хүн бүр төрөлхөөсөө эрх чөлөөтэй, тэгш эрх эдлэх тухай үзэл санаа нь хожим хүн бүр жам ёсны үндсэн эрхээ эдлэх ёстой бөгөөд үүнийг Үндсэн хуулиар хамгаалах ёстой гэсэн жишиг тогтоосон юм. Ийнхүү үзэл бодлын эрх чөлөөний анхны улс төр, гүн ухааны үндэслэлийг 1644 онд Жон Мильтон “Ареопагитика” хэмээх алдарт бүтээлдээ тодорхойлон “үнэнийг олох” хам-

гийн найдвартай зам нь үзэл бодлын чөлөөтэй, нээлттэй солилцоо, илэрхийлэл” хэмээн тунхаглажээ (Болд-Эрдэнэ, 2015). Мөн Францын алдарт философич, хуульч, соён гэгээрүүлэгч Барон де Монтескье 1748 онд бичсэн “Хуулийн амин сүнс” номдоо “Эрх чөлөөг эдлэхийн тулд ямар ч хүн бодож байгаа зүйлээ хэлж чаддаг байх хэрэгтэй. Эрх чөлөөг авч үлдэхийн тулд бас хүн бүр бодож байгаа юмаа хэлж сурах хэрэгтэй. Иймээс улсын иргэн хүн хуулийн заалтаар ярьж, бичихийг хориглоогүй бүх юмыг ярьж, бичих эрхтэй” (Монтескье, 2019) гэж үзэж байжээ.

Харин Английн хуульч, философич, эрх зүйн онолч Жэрэми Бентам (1747–1832) үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийг хамгийн анх хүний үндсэн эрх хэмээн үзсэн. Тэр бээр үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх эрх, хуулиудыг хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө тэдгээрийг олон нийтэд хэвлэн тараах, захиргааны байгууллагуудыг хуулиар хянах, гэм буруугүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх болон албадлага хэрэглэхийг хориглох, эрх зүйн хамгийн гол зарчим болсон *nulla poena sine lege* буюу хуульгүй бол ялгүй зэргийг Үндсэн хуульд ёсны тулгуур зарчимд тооцсон (Өнөрбаяр, 2014) байна. Үүнээс хойш улс орнууд эдгээр эрхийг Үндсэн хуульдаа ямар нэг байдлаар тусгаж иржээ. Хожим зуу гаруй жилийн дараа Жэрэми Бентамын энэ үзэл санаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (ХЭТТ)-ын чухал хэсэг болсон билээ. ХЭТТ-д “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд

үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана” гэж заасан. ХЭТТ бол олон сая хүний амь насны төлөөсөөр ирсэн гашуун сургамжийг дахин давтахгүйн тулд улс орнуудын хамтран баталсан хүн төрөлхтний сайн сайхан, энх тайван амьдрах үндсэн суурь нөхцөлүүдийг тунхагласан нэн чухал баримт бичиг билээ. Дэлхийн хоёрдугаар дайны дараа олон улсад ялгаварлан гадуурхахгүй байх явдлыг хүний эрхийн гол зарчим болгосон. ХЭТТ-ын нэгдүгээр зүйлд “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна” (Unitednation, n.d.) гэж заасан. Учир нь хүний түүх нь бусдыг ялгаварлан гадуурхаж, хүлцэн тэвчиж чадаагүйгээс болж хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдэж, хоморголон устгасан нэн харуусалтай сургамжаар дүүрэн байдаг. Ялгаварлан гадуурхах үзэл нь өөрөө хүний нэр төр, тэгш эрхийг зөрчих явдлын гол шалтгаан байсаар ирсэн. Харин ялгаварлан гадуурхуулахгүй байх, хүн өөрийн эрхэм чанараа хамгаалахад үзэл бодлоо илэрхийлэх боломжтой байх нь тэргүүний шаардлага болдог. Олон зууны турш хүний өөрийн төрөлдөө учруулсан боолчлол, харгис эрүү шүүлт, удам угсаагаар нь хоморголон устгах нь ерөөс үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг хянаж, цагдсантай холбоотой байлаа. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь олон улсын хэмжээнд хүний эрхийн дэг журам, хүний эрхэм чанарын гол цөм нь гэж үздэгийг дэлхий даяар олон улсын болон үндэсний хэмжээний байгууллага, шүүхүүд төдийлөн мэддэггүй (Callamard, 2008).

Түүнчлэн үзэл бодлоо илэрхийлэх эрхийн агуулгыг дараах хэдэн шинжээр илэрч болно гэж хуульч Б.Чимид үзсэн.

- Хүний өөрийн итгэл үнэмшилд суурилдаг.
- Хүний өөрийн буюу бие даасан байр суурийг илэрхийлдэг.
- Нийгэм, төр түүний байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг үнэлж цэгнэх, ариусгахад болон хүний ашиг сонирхлыг хамгаалахад чиглэдэг.
- Нийгмийг жолоодох, хянахад иргэний нийгмийн оролцох арга зам болдог.
- Үг хэлэх, хэвлэн нийтлэх, жагсаал цуглаан хийх, мэдээлэл хайх, олох, түгээх зэрэг бусад эрх, эрх чөлөөгөөр дамжин илэрдэг (Чимид, 2001) гэж тайлбарлажээ.

3. Хэвлэлийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн харилцан хамаарал

Хоёр зууны турш үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь хэвлэлийн эрх чөлөөтэй хам шинжтэй, нягт холбогдож ирлээ. Хэрэв иргэд үзэл бодлоо илэрхийлэх эрхгүй бол хэвлэл нь ч мөн мэдээлэл авах, түгээх боломжгүй. Хэрэв хэвлэл нь эрх чөлөөгүй бол иргэдийн үзэл бодлын үнэ цэн нь нийгмийн гол хүчин зүйл байж чадахгүй. Гэхдээ үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөө гэсэн ойлголтууд нь хоорондоо ялгаатай. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь нөгөөгөөсөө нэлээд өргөн утгатай. Энэ нь ямар мөн чанар агуулгатай (үзэл бодол, санаа, мэдээлэл, урлаг гэх мэт) байхаас хамаардаг.

Хүний үзэл бодолтой байх эрх чөлөөний үнэ цэн нь эрүүл, зөв, бодит байр суурь, хандлага бөгөөд тийм нийгмийн зөвшилцөл, нэгдмэл соёлын

шалгуур дээдлэлийг бий болгох нь үзэл бодлын эрх чөлөөтэй байхуйн утга учир шалтгаан юм. Хэрвээ ийм түвшин нөлөөнд хүрэхгүй аваас энэхүү эрхэм дээд эрх чөлөөний хэрэг, ач тус гэж үгүй болно. Нэг нь ярьж л байдаг, нөгөө нь үл ойшоодог үзэл бодлын үнэ цэн гэж үгүйн дээр хэт даамжран угшваас хүний ч тэр, нийгмийн ч тэр мөн чанар, дэг журамд сөргөөр нөлөөлнө (Болд-Эрдэнэ, 2015). Харин хэвлэлийн эрх чөлөө нь мэдээлэл авах, боловсруулах, түгээх буюу хэвлэн нийтлэх боломжтой байх нөхцөл юм.

Италийн Рома Трэ Их Сургуулийн Харьцуулсан эрх зүйн тэнхимийн профессор, судлаач Винсенцо Зено-Зенкович “Хэрэв үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө баталгаатай бол үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд хэвлэл мэдээллийг ашигладаг учраас хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалах шаардлагатай болдог. Үүнийг жишээгээр задлан, үндэслэлийг нь логикоор илэрхийлбэл: Х (дарс) хамгаалагдсан; Х (дарс)-ыг хамгаалахын тулд Ү (лонх) шаардлагатай, Ү (лонх) хамгаалагдсан яагаад гэвэл Х (дарс) агуулж байгаа учраас. Иймээс лонхон дотор ус байсан ч хамгаалагдах эрхийг доторх бодисоос хадгалж буй сав руу шилжүүлсэн гэсэн үг (Zeno-Zencovich, 2008) гэж тайлбарласан. Тодруулбал, дарс нь лонхгүйгээр оршин тогтнож, хэрэглэгдэх боломжгүй бол лонх нь дарсгүйгээр хамгаалагдах үнэ цэнгүй болно. Үүн лүгээ үзэл бодлоо илэрхийлэх эрх нь хүний хүн байх эрхэм чанартай холбоотой, хамгаалахаас аргагүй үнэ цэнтэй бөгөөд үүнийг хэвлэлийн эрх чөлөө гэсэн саванд хийж хамгаалдаг. Хэрэв үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалж, дотроо агуулахгүй

юм бол хэвлэлийн эрх чөлөө өөрөө үнэ цэнгүй болох юм. Бүр товчилбол, үг дангаараа ярьдаггүй. Үгийг олон нийтэд хүргэж, учир утгатай болгоход дамжуулагч хэрэгтэй. Хэвлэлийн эрх чөлөө нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дотроо агуулдаг, хамгаалдаг, дамжуулдаг тэр нөхцөл нь юм. Дарсыг хадгалагч тэрхүү сав нь хэрэглэхэд болон хадгалахад хялбар, гоо зүйтэй, найдвартай, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй зэрэг шинж чанартай байх нь лонхтой дарсны үнэ цэнийг улам өргөх буй. Хэрэв хэвлэлийн эрх чөлөө гэдэг сав хэврэг, найдваргүй бол доторх дарс (үзэл бодлоо илэрхийлэх эрх) нь хэчнээн амт чанартай байсан ч хэзээ мөдгүй урсаж, асгарах эрсдэлт нөхцөлд байна гэсэн үг.

Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний нөхцөл байдал нь интернэт орчин, нийгмийн сүлжээ зэрэг технологийн шинэ үзэгдлүүдээс улбаалан дахин шинэ шинэ сорилтуудтай тулгарч эхэлсэн. Хүн төрөлхтөнд бичиг үсэг нь үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэх өргөн боломж олгосон бол хэвлэл мэдээллийн шинэ хэрэгсэл бий болох бүрд энэхүү эрх улам хүрээгээ тэлж, өргөждөг. Улам хүч нөлөөтэй болж буй үзэл бодлын орон зайг хянах гэсэн төр, засгийн газруудын оролдлогууд үүнийг дагаад идэвхэждэг. Энэ зүй тогтол ч нийгмийн сүлжээ болон бусад шинэ медиагийн нөлөөгөөр дахин “идэвхэжсэн” гэж хэлж болно. НҮБ-аас улс орны засгийн газрууд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд халдахдаа шүүхийн тогтолцоог “буруугаар” ашиглаж байна (ЮНЕСКО, 2023) гээд 2022 оны тусгай тайландаа дараах бэрхшээлүүдийг дурджээ.

-160 улсад нэр хүнд гутаахыг “эрүүжүүлсэн” хэвээр байгаа бөгөөд нэр

хүнд гутаахыг гэмт хэрэгт тооцохгүй болох явдал удааширч байна. (Монгол Улсын Эрүүгийн хуульд үзэл бодлоо илэрхийлсний төлөө эрүүгийн хариуцлага оноохгүй буюу “гэмт хэрэг” гэж тооцохгүй байхаар заасан. Гэвч энэ заалтыг, хууль, шүүхийн практикт төдийлөн ашигладаггүй. Үзэл бодол, шүүмжлэл, гүтгэлэг, доромжлолыг хэрхэн ялгаж салгах талаар хууль зүйн тайлбар бүрхэг, хуулийн байгууллагууд ялгаатайгаар хэрэглэж чадахгүй байгаа нь хамгийн том бэрхшээл болж байна.)

-Онлайн илэрхийллийг хязгаарлахын тулд нэр хүнд гутаахтай холбоотойгоор хэрэглэж буй эрүүгийн хэрэг, зөрчил дэлхий даяар нэмэгджээ. (Монголд Эрүүгийн хуулийн “илт худал мэдээлэл тараах” тухай буюу 13.14 дүгээр заалтаар шүүхээс шийтгэл оноосон хэргүүдийн ихэнх нь фейсбүүктэй холбоотой байна.)

-Хэд хэдэн улс кибер аюулгүй байдал, “худал мэдээ”, үзэн ядах үг хэллэгийн асуудлыг шийдвэрлэхийн тулд гүтгэлэг, нэр хүнд гутаах, доромжлохтой холбоотой зүйл заалтуудаа хүндрүүлсэн, эсвэл сэргээн баталсан байна. (Монголд нэр хүнд гутаасан үйлдлийг “илт худал мэдээлэл”-д хамааруулан Эрүүгийн хуулиар зохицуулж байна. Мөн доромжлох үйлдлийг Эрүүгийн хуульд оруулахаар хуулийн төсөл

боловсруулсан. Мөн дээрх шалтгаанаар Засгийн газар 2023 онд иргэдийн онлайн орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарласан “Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль”-ийг баталсан ч хүчингүй болгосон билээ.)

-Шүүмжлэлт дуу хоолойг дарах, олон нийтийн хяналтыг сулруулахын тулд хүчирхэг тоглогчид зориудаар, зохион

байгуулалттайгаар нэгэн зэрэг шүүх, хуулийн байгууллагад олон гомдол, нэхэмжлэл гаргах практик нэмэгдэж байна. (Монголд төрийн байгууллага болон улс төр, эдийн засагт нөлөө бүхий хүмүүс Хэвлэл мэдээллийн зөвлөл, Эрүүгийн шүүх, Иргэний шүүхэд зэрэгцүүлэн гомдол гаргах явдал түгээмэл болсон. Сэтгүүлч Н.Өнөрцэцэгийг богино хугацаанд олон хэрэгт хамааруулан шалгаж буй нь шүүхийг “буруугаар ашиглаж” буйн

«

Үзэл бодлоо илэрхийлэх эрх нь чухал бөгөөд эмзэг байх тусам түүнийг хамгаалагч хэвлэлийн эрх чөлөө найдвартай байх ёстой. Гэтэл хэвлэлийн эрх чөлөө хэврэг, түүний бүрдэл нөхцөлүүд “найдваргүй” байгааг Монгол Улсын хэвлэлийн эрх чөлөөний индекс харуулна. Үзэл бодлоо илэр-хийлэх эрх, хэвлэлийн эрх чөлөөний нөхцөл байдал нь бие биеэсээ нэн хамааралтай цаг үед бид амьдарч байна. Үүнийг “лонхтой дарс”-аар тайлбарлахад хангалттай биз

ЭЭ

»

нэг жишээ юм.)

Онлайн сүлжээнд өргөжин тэлж буй үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг Засгийн газрууд, эрх мэдэлтнүүд хянахын тулд “нэр төр, алдар хүнд, нийгмийн сайн сайхан” гэсэн шалтаг, шалтгаанаар олон янзын хэлбэрээр шахан хавчих болсон нь зөвхөн Монголд буй үзэгдэл биш ажээ. Үзэл бодлоо илэрхийлэх эрх нь чухал бөгөөд эмзэг байх тусам түүнийг хамгаалагч хэвлэлийн эрх чөлөө найд-

вартай байх ёстой. Гэтэл хэвлэлийн эрх чөлөө хэврэг, түүний бүрдэл нөхцөлүүд “найдваргүй” байгааг Монгол Улсын хэвлэлийн эрх чөлөөний индекс харуулна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх, хэвлэлийн эрх чөлөөний нөхцөл байдал нь бие биеэсээ нэн хамааралтай цаг үед бид амьдарч байна. Үүнийг “лонхтой дарс”-аар тайлбарлахад хангалттай биз ээ.

Эрх чөлөө нь байнга хөгжих өргөн агуулгатай. Иймийн тул үзэл бодлоо илэрхийлэх эрх, хэвлэлийн эрх чөлөөний агуулга, хүрээг зөвхөн дээр дурдсанаар хумьж ойлгож болохгүй. Цаг үе, технологи, нийгмийн хөгжил, өрнөлөөр энэхүү хоёр ойлголтын талаарх үзэл санаа, хоорондын харилцан хамаарлын асуудал ч улам нарийсан, өргөжих билээ.

Эшлэл

1. Наранжаргал, Х. (2021). Чөлөөт илэрхийлэл ба чөлөөт сэтгүүл зүй. УБ. х46.
2. <https://freedomhouse.org/issues/media-freedom>
3. <https://www.whitehouse.gov/about-the-white-house/our-government/the-constitution/#:~:text=The%20First%20Amendment%20provides%20that,the%20right%20to%20bear%20arms.>
4. <https://www.whitehouse.gov/about-the-white-house/our-government/the-constitution/#:~:text=The%20First%20Amendment%20provides%20that,the%20right%20to%20bear%20arms.>
5. Болорсайхан, Б. (2021). Эмэгтэйчүүдийн эрх: Түүхэн хөгжил болон эрх зүйн баримт бичгүүд// Төрийн байгуулал. №4. Конрад-Аденуэр сан. УБ. х36.
6. Болд-Эрдэнэ, Б. (2015) “Сэтгүүл зүй”. Үзэл бодлоо илэрхийлэх, үзэл бодолтой байх эрх чөлөөний өнөөгийн байдал. ЭШӨ. УБ. х155.
7. Монтескье, Барон де.(2019). Хуулийн амин сүнс. УБ. х267.
8. Өнөрбаяр, Ч. (2014). Үндсэн хуульт ёсны хөгжил, түүний чиг хандлага. УБ. х12.
9. <https://www.un.org/en/about-us/universal-declaration-of-human-rights>
10. Agnès Callamard. (2008). Freedom of expression and advocacy of religious hatred that constitutes incitement to discrimination, hostility or violence// Expert seminar on the links between articles 19 and 20 of the international covenant on civil and political rights. Geneva. p7.
11. Чимид, Б. (2001). Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө // “Сэтгүүлч ба хууль цуврал” №3. УБ. х.10.
12. Болд-Эрдэнэ, Б. (2015). Үзэл бодлоо илэрхийлэх, үзэл бодолтой байх эрх чөлөөний өнөөгийн байдал // “Сэтгүүл зүй” сэтгүүл №16 (438). х152.
13. Vincenzo Zeno-Zencovich. (2008). Freedom of expression, a critical and comparative analysis. London. p206.
14. ЮНЕСКО. (Глоб интернэйшнл төв орчуулсан)(2023). Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд халдахдаа шүүхийн тогтолцоог “буруугаар ашиглах” нь. УБ. х3.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болд-Эрдэнэ, Б. (2015) “Сэтгүүл зүй”. Үзэл бодлоо илэрхийлэх, үзэл бодолтой байх эрх чөлөөний өнөөгийн байдал. ЭШӨ. УБ.
2. Болорсайхан, Б. (2021). Эмэгтэйчүүдийн эрх: Түүхэн хөгжил болон эрх зүйн баримт бичгүүд// Төрийн байгуулал. №4. Конрад-Аденуэр сан. УБ.
3. Монтескье, Барон де. (2019). Хуулийн амин сүнс. УБ.
4. Мөнхсайхан.О. Эрх зүйн философи. 2022. УБ.
5. Наранжаргал, Х. (2021). Чөлөөт илэрхийлэл ба чөлөөт сэтгүүл зүй. УБ.
6. Өнөрбаяр, Ч. (2014). Үндсэн хуульт ёсны хөгжил, түүний чиг хандлага. УБ.

7. Чимид, Б. (2001). Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө // “Сэтгүүлч ба хууль цуврал” №3. УБ.
8. ЮНЕСКО. (Глоб интернэйшнл төв орчуулсан) (2023). Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд халдахдаа шүүхийн тогтолцоог “буруугаар ашиглах” нь. УБ.
9. Agnès Callamard. (2008). Freedom of expression and advocacy of religious hatred that constitutes incitement to discrimination, hostility or violence // Expert seminar on the links between articles 19 and 20 of the international covenant on civil and political rights. Geneva.
10. Vincenzo Zeno-Zencovich. (2008). Freedom of expression, a critical and comparative analysis. London.
11. <https://freedomhouse.org/issues/media-freedom>
12. <https://www.law.cornell.edu/>
13. <https://rsf.org/en/country/mongolia>
14. <https://www.un.org/en/about-us/universal-declaration-of-human-rights>
15. <https://www.whitehouse.gov/about-the-white-house/our-government/the-constitution/#:~:text=The%20First%20Amendment%20provides%20that,the%20right%20to%20bear%20arms.>
16. [https://www.whitehouse.gov/about-the-white-house/our-government/the-](https://www.whitehouse.gov/about-the-white-house/our-government/the-constitution/#:~:text=The%20First%20Amendment%20provides%20that,the%20right%20to%20bear%20arms.)

[constitution/#:~:text=The%20First%20Amendment%20provides%20that,the%20right%20to%20bear%20arms.](https://www.whitehouse.gov/about-the-white-house/our-government/the-constitution/#:~:text=The%20First%20Amendment%20provides%20that,the%20right%20to%20bear%20arms.)

Summary

In the last two centuries, the concepts of freedom of the press and the right to freedom of expression have been used side by side. Freedom of the press has come to be seen as a basic human rights issue and a vital indicator of democracy rather than just a matter of media workers and journalists. It is an overgeneralization that journalists must protect the freedom of the press because they protect the interests of the public. When the freedom of the press and the right to freedom of expression are facing a dangerous situation around the world, it is important to know the basic content, interrelationship, and regularity of the right to freedom of expression and the freedom of the press. Today, the idea of democracy, human rights, and a humane society has spread worldwide, but the freedom of the press is in a dangerous and fragile situation. This article aims to broadly explain what is included in the concept of freedom of the press and the right to freedom of expression, and how they are interrelated.

Keywords: freedom of the press, the right to express opinions, human rights, and legal regulation of the media.